

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2025/068/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Чингис хот  
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 91913204 Цахим хаяг: ganbaatarj@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунаа  
Утас: 99195208 Цахим хаяг: ariunaab@audit.gov.mn



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-12, Факс: 70-56-21-12  
E-mail: khentii@audit.gov.mn

2025.02.24

№

254

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯН-ОВОО СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Р.ОЮУНЧИМЭГ ТАНАА

### Г Хязгаарлалттай дүгнэлт 1

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

#### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн зөрчлүүд бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

Засаг даргын нөөц сангаас урьдчилан төлөвлөх боломжтой зардалд хөрөнгө зарцуулсан, баяр наадмын арга хэмжээний зардалд батлагдсан жишиг нормыг хэтрүүлсэн, гамшгийн үед хөнгөлөлттэй үнээр худалдан авсан болон тусламж, дэмжлэгээр ирсэн өвс, тэжээлийг эд хариуцагчийн тайланд тусгалгүй шууд зарлагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 24 дүгээр зүйлийн 24.7, Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан жишиг дээд хэмжээ, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5-д заасантай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,156,432.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 2,600.0 мянган төгрөг нийт 1,159,032.4 мянган төгрөгийг төвлөрүүлэн зарцуулж, 203,909.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Мөрийн хөтөлбөр, засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулах шаардлагатай байна.

232520254

## **Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 196,519.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 112,321.5 мянган төгрөгийн 3 алдааг аудитын явцад залруулж, 2,410.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 81,787.3 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

## **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 115 зорилтын хүрээнд 257 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, гүйцэтгэл 92.4 хувийн биелэлттэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>69,687,128.76</b>	<b>78,928,644.13</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>123,573.09</b>	<b>8,998,088.46</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	123,573.09	4,498,088.46
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	<b>4,500,000.00</b>
<b>3351</b>	<b>Байгууллагаас авах авлага</b>	-	<b>4,500,000.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>69,563,555.67</b>	<b>69,930,555.67</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>51,304,339.00</b>	<b>53,948,339.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	51,304,339.00	53,948,339.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>14,499,216.67</b>	<b>15,982,216.67</b>
35410	Бичиг хэргийн материал	1,615,000.00	1,515,000.00
35420	Аж ахуйн материал	12,884,216.67	14,467,216.67
35600	Мал амьтад	3,760,000.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,772,357,313.96</b>	<b>6,336,460,905.48</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,772,357,313.96</b>	<b>6,336,460,905.48</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,561,541,313.96</b>	<b>6,125,644,905.48</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,004,293,796.30	6,792,861,852.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(721,924,856.82)	(1,010,153,290.86)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	210,804,953.00	322,304,953.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(91,276,298.02)	(130,436,286.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	359,633,151.84	378,052,613.77
39206	Хуримтлагдсан элэгдэл	(249,080,871.37)	(303,834,966.82)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,638,097.00	85,989,497.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(34,234,987.51)	(39,621,451.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	80,839,924.20	80,839,924.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	(40,151,594.66)	(50,357,939.66)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>210,816,000.00</b>	<b>210,816,000.00</b>
39301	Програм хангамж	280,000.00	280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(280,000.00)	(280,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	210,816,000.00	210,816,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,842,044,442.72</b>	<b>6,415,389,549.61</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,842,044,442.72</b>	<b>6,415,389,549.61</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>5,842,044,442.72</b>	<b>6,415,389,549.61</b>
<b>511</b>	<b>Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан</b>	<b>337,839,474.00</b>	<b>337,839,474.00</b>
<b>51101</b>	<b>Өмч: - төрийн</b>	<b>337,839,474.00</b>	<b>337,839,474.00</b>
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>5,216,906,637.90</b>	<b>5,790,251,744.79</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	2,117,572,615.79	5,216,906,637.90
51220	Тайлант үеийн үр дүн	3,099,334,022.11	573,345,106.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	287,298,330.82	287,298,330.82
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>5,842,044,442.72</b>	<b>6,415,389,549.61</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,208,774,551.30</b>	<b>2,098,848,914.93</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,420,207,417.30</b>	<b>792,467,859.93</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>3,420,207,417.30</b>	<b>792,467,859.93</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,420,207,417.30	792,467,859.93
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,600,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,006,000.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,417,201,417.30	789,867,859.93
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>788,567,134.00</b>	<b>1,306,381,055.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>55,005,834.00</b>	<b>149,948,655.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,752,434.00	141,065,655.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,253,400.00	8,883,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>733,561,300.00</b>	<b>1,156,432,400.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	733,561,300.00	1,156,432,400.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,107,140,529.19</b>	<b>1,521,743,808.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,067,140,529.19</b>	<b>1,521,743,808.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>962,309,639.13</b>	<b>1,290,026,098.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>346,661,914.48</b>	<b>507,392,047.26</b>
210101	Үндсэн цалин	313,791,872.23	303,189,606.74
210102	Нэмэгдэл	28,019,922.25	167,387,986.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,531,000.00	3,055,000.00
210104	Урамшуулал	1,825,320.00	00.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,493,800.00	33,759,454.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,851,456.70</b>	<b>63,666,431.59</b>
210201	Тэтгэврийн даатгал	34,223,664.53	43,472,703.87
210202	Тэтгэмжийн даатгал	2,444,499.87	5,096,322.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,945,956.67	2,686,142.58
210204	Ажилгүйдлийн даатгал	493,855.05	2,476,301.39
210205	Эрүүл мэндийн даатгал	4,743,480.58	9,934,961.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,403,145.27</b>	<b>38,345,810.52</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,043,716.27	20,503,873.10
210302	Түлш, халаалт	15,359,429.00	16,499,572.66
210303	Цэвэр, бохир ус	00.00	1,342,364.76
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,896,773.10</b>	<b>50,911,779.70</b>
210401	Бичиг хэрэг	3,400,500.00	4,830,200.00
210402	Тээвэр, шатахуун	20,737,173.10	38,429,379.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,905,800.00	3,224,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,853,300.00	4,332,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,110,000.00</b>	<b>862,600.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,110,000.00	862,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>7,319,530.00</b>	<b>54,284,050.01</b>
210602	Тавилга	00.00	24,500.01
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	300,000.00	00.00
210604	Урсгал засвар	7,019,530.00	54,259,550.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,866,000.00</b>	<b>15,458,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,866,000.00	15,458,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>132,172,162.00</b>	<b>105,218,840.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,554,850.00	102,724,209.00
210803	Даатгалын үйлчилгээ	387,967.00	1,008,623.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	703,221.00	72,508.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	516,000.00	450,000.00

210807	Газрын төлбөр	988,124.00	963,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>365,028,657.58</b>	<b>453,886,539.40</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,827,047.50	55,845,713.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	330,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	327,501,610.08	397,710,826.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>104,830,890.06</b>	<b>231,717,709.56</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>63,966,500.00</b>	<b>27,711,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,939,500.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	24,102,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,027,000.00	3,609,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>40,864,390.06</b>	<b>203,909,177.78</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,864,390.06	203,909,177.78
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>97,531.78</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	97,531.78
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,000,000.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>40,000,000.00</b>	<b>00.00</b>
223001	Бусад хөрөнгө	40,000,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>3,101,634,022.11</b>	<b>577,105,106.89</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,300,000.00</b>	<b>3,760,000.00</b>
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	2300000.00	3760000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-2,300,000.00</b>	<b>-3,760,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>3,099,334,022.11</b>	<b>573,345,106.89</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>791,573,134.00</b>	<b>1,308,981,055.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,006,000.00</b>	<b>2,600,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,006,000.00	2,600,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,006,000.00	2,600,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,006,000.00	2,600,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>788,567,134.00</b>	<b>1,306,381,055.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	55,005,834.00	149,948,655.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,752,434.00	141,065,655.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,253,400.00	8,883,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	733,561,300.00	1,156,432,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	733,561,300.00	1,156,432,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>751,515,642.20</b>	<b>1,144,285,997.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>751,515,642.20</b>	<b>1,144,285,997.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>646,584,752.14</b>	<b>908,068,287.44</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>347,020,077.48</b>	<b>507,715,737.60</b>
210101	Үндсэн цалин	223,811,695.01	303,189,606.74
210102	Нэмэгдэл	90,273,929.03	167,387,986.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,470,903.83	3,055,000.00
210104	Урамшуулал	1,825,320.00	-
210105	Гэрээт ажлын хөлс	27,638,229.61	34,083,144.74
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,404,116.79</b>	<b>67,636,822.62</b>
210201	Тэтгэврийн даатгал	28,235,436.86	47,443,094.90
210202	Тэтгэмжийн даатгал	3,792,280.00	5,096,322.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,033,700.00	2,686,142.58
210204	Ажилгүйдлийн даатгал	758,400.00	2,476,301.39
210205	Эрүүл мэндийн даатгал	7,584,299.93	9,934,961.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>30,066,545.27</b>	<b>38,345,810.52</b>
210301	Гэрэл, цахилгаан	15,043,716.27	20,503,873.10
210302	Түлш, халаалт	14,021,329.00	16,499,572.66
210303	Цэвэр, бохир ус	1,001,500.00	1,342,364.76
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>22,202,673.30</b>	<b>32,023,436.70</b>
210401	Бичиг хэрэг	2,487,500.00	3,531,200.00
210402	Тээвэр, шатахуун	15,877,073.30	23,258,236.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,905,800.00	3,334,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,932,300.00	1,804,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,582,000.00</b>	<b>1,512,600.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	<b>1,582,000.00</b>	<b>1,512,600.00</b>
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,613,530.00</b>	<b>48,127,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,800,000.00	1,010,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	615,000.00	940,000.00
210604	Урсгал засвар	6,198,530.00	46,177,000.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	<b>7,866,000.00</b>	<b>15,458,000.00</b>
210702	Дотоод албан томилот	7,866,000.00	15,458,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>142,935,870.00</b>	<b>133,556,614.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	140,258,558.00	130,995,983.00
210803	Даатгалын үйлчилгээ	721,192.00	1,008,623.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	379,996.00	72,508.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	72,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	516,000.00	516,000.00
210807	Газрын төлбөр	988,124.00	963,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>42,893,939.30</b>	<b>63,692,266.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	41,110,939.30	62,495,266.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,783,000.00	1,197,000.00

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>104,930,890.06</b>	<b>236,217,709.56</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>64,066,500.00</b>	<b>27,711,000.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	55,939,500.00	-
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	24,102,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,127,000.00	3,609,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>40,864,390.06</b>	<b>203,909,177.78</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,864,390.06	203,909,177.78
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>4,597,531.78</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	4,597,531.78
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>40,057,491.80</b>	<b>164,695,058.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>40,000,000.00</b>	<b>164,695,058.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>40,000,000.00</b>	<b>164,695,058.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>40,000,000.00</b>	<b>164,695,058.00</b>
223001	Бусад хөрөнгө	40,000,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	164,695,058.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(40,000,000.00)</b>	<b>(164,695,058.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>≡</b>	<b>≡</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>57,491.80</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
<b>C01</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	337,839,474.00	287,298,330.82	<b>2,117,572,615.79</b>	-	<b>2,742,710,420.61</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,839,474.00	287,298,330.82	2,117,572,615.79	-	<b>2,742,710,420.61</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	3,099,334,022.11	-	<b>3,099,334,022.11</b>
<b>C08</b>	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	337,839,474.00	287,298,330.82	<b>5,216,906,637.90</b>	-	<b>5,842,044,442.72</b>
<b>D01</b>	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	337,839,474.00	287,298,330.82	<b>5,216,906,637.90</b>	-	<b>5,842,044,442.72</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	337,839,474.00	287,298,330.82	5,216,906,637.90	-	<b>5,842,044,442.72</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	573,345,106.89	-	<b>573,345,106.89</b>
<b>D09</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	337,839,474.00	287,298,330.82	<b>5,790,251,744.79</b>	-	<b>6,415,389,549.61</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,159,032,400.00</b>	<b>955,123,222.22</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,115,657,200.00</b>	<b>911,771,822.22</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,087,941,100.00</b>	<b>884,060,822.22</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>684,983,000.00</b>	<b>507,715,737.60</b>
210101	Үндсэн цалин	406,593,600.00	303,189,606.74
210102	Нэмэгдэл	235,916,800.00	167,387,986.12
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,672,600.00	3,055,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,800,000.00	34,083,144.74
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>85,623,100.00</b>	<b>67,636,822.62</b>
210201	Тэтгэврийн даатгал	58,223,700.00	47,443,094.90
210202	Тэтгэмжийн даатгал	6,849,900.00	5,096,322.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,424,900.00	2,686,142.58
210204	Ажилгүйдлийн даатгал	3,424,900.00	2,476,301.39
210205	Эрүүл мэндийн даатгал	13,699,700.00	9,934,961.58
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,704,800.00</b>	<b>34,704,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,011,400.00	17,010,608.24
210302	Түлш, халаалт	16,493,400.00	16,351,827.00
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,342,364.76
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,635,600.00</b>	<b>27,503,862.00</b>
210401	Бичиг хэрэг	3,614,300.00	3,531,200.00
210402	Тээвэр, шатахуун	18,840,000.00	18,738,662.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,278,200.00	3,334,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	96,000.00	96,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,807,100.00	1,804,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,513,100.00</b>	<b>1,512,600.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,513,100.00	1,512,600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>53,905,900.00</b>	<b>53,872,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,762,800.00	6,755,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	943,100.00	940,000.00
210604	Урсгал засвар	46,200,000.00	46,177,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>16,500,000.00</b>	<b>15,458,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	16,500,000.00	15,458,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>131,986,800.00</b>	<b>124,633,714.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	129,417,800.00	122,073,083.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,014,300.00	1,008,623.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	73,400.00	72,508.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	600.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	516,400.00	516,000.00
210807	Газрын төлбөр	963,500.00	963,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>51,088,800.00</b>	<b>51,023,286.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,889,900.00	49,826,286.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,198,900.00	1,197,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>27,716,100.00</b>	<b>27,711,000.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>27,716,100.00</b>	<b>27,711,000.00</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	24,102,000.00	24,102,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,614,100.00	3,609,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>43,375,200.00</b>	<b>43,351,400.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>43,375,200.00</b>	<b>43,351,400.00</b>
223001	Бусад хөрөнгө	43,375,200.00	43,351,400.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,159,032,400.00</b>	<b>955,123,222.22</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,156,432,400.00</b>	<b>952,523,222.22</b>
132001	Орон нутгийн төсвөөс	1,156,432,400.00	952,523,222.22
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,600,000.00	2,600,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,600,000.00	2,600,000.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>149,948,655.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,649,997.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>30,052,465.22</b>
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>3,641,010.52</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,493,264.86
210302	Түлш, халаалт	147,745.66
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,519,574.70</b>
210402	Тээвэр, шатахуун	4,519,574.70
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>8,922,900.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,922,900.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>12,968,980.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,968,980.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,597,531.78</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	4,597,531.78
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>115,298,658.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	115,298,658.00
223001	Бусад хөрөнгө	115,298,658.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>149,948,655.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>149,948,655.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	141,065,655.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8,883,000.00

## **Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

---

Аудитаар нийт 112,321.5 мянган төгрөгийн төгрөгийн 3 алдаа илэрснээс аудитын явцад залрууллаа.

Үүнд:

Засаг даргын үйл ажиллагааны зардлаас худалдан авсан тоног төхөөрөмжийг шууд зардалд бүртгэснийг үндсэн хөрөнгөд бүртгэж залруулсан.

ХХААХҮЯ-аас нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 10,000.0 мянган төгрөгийн орлого, 381.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг дутуу бүртгэснийг орлого, зардалд бүртгэв.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийсэн сумын зам засварын зураг төсвийг үндсэн хөрөнгөд бүртгэснийг урьдчилж төлсөн зардлаар бүртгэж залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 84,197.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,410.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 81,787.3 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлсэн байна.

### **5.1 Төлбөрийн акт**

Төрийн захиргааны албан хаагчдад олгосон 24,102.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас ХХОАТ-ыг суутгаагүй олгосон. хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д "энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх" гэснийг хэрэгжүүлээгүй зөрчсөн байна.

### **5.2 Албан шаардлага**

Засаг даргын нөөц сангаас 3,669.0 мянган төгрөгийн урьдчилан төлөвлөх боломжтой зардал, 6,126.1 мянган төгрөгийн наадмын зардалд зарцуулсан.

Баяр наадмын арга хэмжээний зардалд 14,126.1 мянган төгрөг зарцуулсан нь батлагдсан жишиг нормоос хэтэрсэн байна.

Гамшгийн үед эрсдэлийн сангаас хөнгөлөлттэй үнээр худалдан авсан болон тусламж, дэмжлэгээр ирсэн 7,730.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг эд хариуцагчийн тайланд тусгаагүй шууд зарлагдсан.

ХХААХҮЯ-аас нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 10,000.0 мянган төгрөгийг нэр данс зөрүүтэй гүйлгээгээр Эко Баян-Овоо ТТБ-ын дансанд шилжүүлж, зарцуулсан.

Засаг даргын тамгын газрын хуучин барилгыг засварлах 46,262.2 мянган төгрөгийн ажлыг тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт дээд өртгийн хязгаарыг баримтлан ажиллаагүй байна.

### **5.3 Зөвлөмж**

Зөвлөмж өгөгдөөгүй.

**Дөрөв. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруул аагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хөрөнгө орлогод бүртгээгүй	1	22,195.0	1	22,195.0			1	22,195.0				
Орлого, зарлагыг бүртгээгүй	1	10,381.0	1	10,381.0			1	10,381.0				
Зураг төсвийн үнийн үндсэн хөрөнгөнд бүртгэсэн	1	79,745.5			1	79,745.5	1	79,745.5				
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>112,321.5</b>	<b>2</b>	<b>32,576.0</b>	<b>1</b>	<b>79,745.5</b>	<b>3</b>	<b>112,321.5</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
ЗДНС-ийн зөрчил	1	9,795.0			1	9,795.0						
Баяр наадмын зардал хэтрүүлсэн	1	8,000.0			1	8,000.0						
Тусламжийн барааг бүртгэдэггүй	1	7,730.0			1	7,730.0						
Нэмэлт дансны орлогыг НДЗ гүйлгээгээр зарлагдсан	1	10,000.0			1	10,000.0						
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>35,525.0</b>			<b>4</b>	<b>35,525.0</b>						

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Барилгын засварын ажилд тендер зарлаагүй	1	46,262.2					1	46,262.2
Урамшууллаас татвар суутгаагүй	1	2,410.2	1	2,410.2				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>48,672.2</b>	<b>1</b>	<b>2,410.2</b>	<b>1</b>	<b>46,262.2</b>		
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>48,672.2</b>	<b>1</b>	<b>2,410.2</b>	<b>1</b>	<b>46,262.2</b>		

  
**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ**

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 74-ХЭА-2025/НА-СТА-ТШЗ Чингис хот  
A2370448

Г Төлбөр барагдуулах тухай Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн захиргааны албан хаагчдад олгосон 24,102.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллаас ХХОАТ-ыг суутган тооцож, төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1."энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд заасан орлогын дүнд энэ хуулийн 21.1-д заасан хувиар албан татвар ногдуулж, холбогдох төсөвт шилжүүлэх;" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох " журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй;" гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Суутган тооцож төсөвт төвлөрүүлээгүй татварын 2,410.2 мянган төгрөгийг аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын дарга Р.Оюунчимэг, нягтлан бодогч С.Наранцэцэг нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА

**232505074**



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 138-ХЭА-2025/068/НА-СТА-ТЦЗ  
А2370448 Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын нөөцөөс 3,669.0 мянган төгрөгийг урьдчилан төлөвлөх боломжтой зардалд, 6,126.1 мянган төгрөгийг баяр наадмын зардалд тус тус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5-д "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээ"-г санхүүжүүлэхэд зориулна гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засаг даргын нөөц сангийн хөрөнгийг зориулалт бус зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Р.Оюунчимэг, нягтлан бодогч С.Наранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Б.АРИУНАА

232504138



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 139-ХЭА-2025/068/НА-СТА-ТШЗ  
А2370448 Чингис хот

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ХХААХҮЯ-аас тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн 10,000.0 мянган төгрөгийг нэр данс зөрүүтэй гүйлгээгээр Эко Баян-Овоо ТТБ-ын дансанд шилжүүлэн зарцуулж, санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

- Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд тусгахгүй зарцуулдаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Р.Оюунчимэг, нягтлан бодогч С.Наранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Ж.ГАНБААТАР  
Б.АРИУНАА



232504139



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 140-ХЭА-2025/068/НА-СТА-ТЦЗ  
А 2370448 Чингис хот

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Засаг даргын тамгын газрын хуучин барилгын засварын 46,262.2 мянган төгрөгийн ажилд тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2-т "Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана." Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт өртгийн дээд хязгаарыг мөрдөн ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.1.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Худалдан авах ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Р.Оюунчимэг, нягтлан бодогч С.Наранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА

232504140



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 141-ХЭА-2025/068/НА-СТА-ТШЗ  
А2370448 Чингис хот

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймагийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Баяр наадмын арга хэмжээний зардалд 14,126.1 мянган төгрөгийг батлагдсан жишиг нормоос хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан "Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай." гэснийг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Баяр наадмын санхүүжилтийн жишиг дээд хэмжээг баримталдаггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Р.Оюунчимэг, нягтлан бодогч С.Наранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ж.ГАНБААТАР

АУДИТОР



Б.АРИУНАА

232504141



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 142-ХЭА-2025/068/НА-СТА-ТШЗ  
А2370448 Чингис хот

Зөрчлийг арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гамшгийн үед эрсдэлийн сангаас хөнгөлөлттэй үнээр худалдан авсан болон тусламж, дэмжлэгээр ирсэн 7,730.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг эд хариуцагчийн тайланд тусгалгүй шууд зарлагадсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.1-д "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага,"-ыг нягтлан бодох бүртгэлд заавал бүртгэнэ гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэсэн заалтыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Нягтлан бодох бүртгэлд тусгахгүй хөрөнгө зарлагаддаг зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг дарга Р.Оюунчимэг, нягтлан бодогч С.Наранцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР



Ж.ГАНБААТАР

Б.АРИУНАА

232504142